



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/432

Ховд

Орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлт
Гхийх шуурхай ажил зохион байгуулах тухай

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Отор нүүдэл, улсын баяр наадмын цаг үе эхлэн хүн, мал, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг бүх нийтийг хамарсан ажил болгож төв суурин газар,улс аймгийн чанартай зам,малын бэлчээр,тариалангийн талбай гол горхи, булаг шандны орчимд үхсэн мал, амьтны хүүр, сэг зэм цуглуулах устгах ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 2019 оны 7 дугаар сарын 04-нээс 15-ны хооронд зохион байгуулахыг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/ , Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Л.Батбаяр/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эдэнэ чулуун/- нарт үүрэг болгосугай.

2.Тухайн ажилд шаардагдах тээврийн хэрэгсэл, шатахуун халдваргүйжүүлэлтийн бодис, бусад зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын нэгдсэн удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, дүн мэдээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажилд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж сум орон нутгийн удирдлага, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд шаардагдах бодис,бэлдмэлийг хангах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

ᠨᠠᠵᠤ Засаг А/432 ᠭᠡᠨ

Аймгийн Засаг даргын 2019 оны 7 дугаар
сарын 02- ны өдрийн А/432 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

УДИРДАМЖ

Орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэх
шуурхай үйл ажиллагааг зохион байгуулах ажлын тухай

Зорилго :

Мал, амьтны сэг зэмээс хамааран хүн , мал амьтны халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх, төв суурин газар орон нутаг, улс аймгийн чанартай зам , бэлчээр нуур, гол горхи булаг шанд, тариалангийн талбай түүхий эдийн зах, малын худалдааны зах, агуулах талбайг халдваргүйжүүлэн цэвэрлэх мал эмнэлэг ариун цэвэр, халдваргүйжүүлэлт орчны цэвэрлэгээний ажлыг аймаг, сум , багийн хэмжээнд шуурхай зохион байгуулахад оршино.

Нэг. Гүйцэтгэх ажил:

А.Сум багийн Засаг даргын захирамж гарган Мал эмнэлэг ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулах.

Б.Тухайн ажилд шаардагдах хүн хүч, унаа тээврийн хэрэгсэл шатахуун болон бусад зардлыг шийдвэрлэж, орон нутгийн байгууллага, малын эмч мэргэжилтэн , малчид иргэдийг өргөнөөр татан оролцуулах.

В.Мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэхэд олон нийтийн үүсгэл санаачилгыг өрнүүлэн тухайн ажлын зорилго, ач холбогдол, хариуцлагын асуудлыг хэрэгжүүлэх.

Хоёр. Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн түвшинд гүйцэтгэх зохион байгуулах ажил:

А. Ариутгал, халдваргүйжүүлэлт, сэг зэм устгалын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

Б.Сэг зэм, хүүр устгах ариутгал, халдваргүйжүүлэлт хийх мэргэжлийн хүмүүсийг усны гутал, хамгаалалтын шил, ус үл нэвтрэх материалаар хийгдсэн хувцас, резинен болон берзинтен бээлий, нүдний шил зэрэг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангагдсан байна.

В.Мал, амьтны хүүр сэг зэмийг өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн хашаа хорооноос алс зайд 500-800 метр зайд авто машин үерийн усны замаас зайдуу газарт 1.5-2 метр гүн нүхэнд 1 малын сэг зэмд 30-50 гр хлорын шохой оногдохоор бодож ариутгалын бодис хийж булах буюу шатааж устгана.

Г. Мал, амьтны хүүр ,сэг зэм байсан газар, тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг хог тоосноос цэвэрлэж 25% идэвхт хлор агуулсан хлорын шохойн 2%-ийн уусмал болон ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисоор зааврын дагуу гүйцэтгэнэ.

Д.Мал амьтны хүүр сэг зэм байсан булаг шандны эхийг цэвэрлэн, малын ялгадас, бороо, цасны ус орохоос хамгаалсан суваг шуудуу татах арга хэмжээ авах,

Е.Ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн ажлын явц, хэрэгжилтэнд мэргэжлийн хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгаж ажиллах.

Гурав:Малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд хийгдэх ажил

А.мэргэжлийн байгууллагын заавар, удирдамжийн дагуу тухайн ажилд идэвхтэй оролцох.

Б.Мал, амьтны хүүр сэг зэмийн байршил газар усыг зааж өгөх.

В,Нуур ус, гол горхи, булаг шанд, худаг уст цэг, авто замын дагуу үхсэн хаяад явсан мал, амьтны сэг зэмийн эзнийг тодруулах, устгахад хамтран ажиллах.

Г.Тухайн гүйцэтгэсэн ажлын үр дүн, ач холбогдлыг бусдад дамжуулан хүргэх түгээх.


Дөрөв. Ажлыг дүгнэх мэдээлэх.

1.Захирамжийн дагуу ажлын гүйцэтгэлийг сумын Мал эмнэлгийн тасаг дээр нэгтгэн сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэцүүлэн тайлан мэдээг аймгийн Мал эмнэлгийн газарт 2019 оны 07 дугаар сарын 15-ны дотор ирүүлсэн байна.

2.Аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлын үр дүнг аймгийн мал эмнэлгийн газар 2019 оны 07 дугаар сарын 20-ны дотор нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлөөр оруулан хэлэлцүүлж 2019 оны 07 дугаар сарын 25-ны дотор Мал эмнэлгийн Ерөнхий газарт хүргүүлнэ.

-oOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны 7 дугаар сарын
02-ны өдрийн А/432 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт



ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ, АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙ ЖҮҮЛЭХ ШУУРХАЙ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ

Д/Д	Сумын нэр	Түүхий эд бүтээгдэхүүн Хадгалах цэг Зоорь, тэжээлийн агуулах		Малын хашаа хороо, мал Мал амьтны тоо		Худаг уст цэг		Халдваргүй-жүүлсэн бүс цэг		Бэлчээрийн талбай м2	Нийт м2		Хэрэглэсэн эмийн төрөл		
		Тоо хэмжээ ширхэг	Талбай м ²	Тоо Хэмжээ ширхэг	Талбай м ²	Тоо	м ²	тоо	м ²		Нэр	Зарцуулсан хэмжээ	Нийт зардал/ мян.төг /		

Мэдээ нэгтгэсэн эмч.....
Гарын үсэг нэр

Хянасан зөвшөөрсөн тасгийн дарга.....

2019 оны сарын өдөр Гарын үсэг нэр